



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒3 оны 05 сарын ᠒3 өдөр

Дугаар А/᠒᠙᠒

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ГАОНӨГ/202312009 дугаар бүхий Газар хагалах анжис хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Х.Нордогбат (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн)


Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Баярмаа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2.Тус ажлыг гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч Бигэр, Цогт, Шарга сумдад хүлээлгэн өгч, үр дүнг танилцуулахыг комисс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Бигэр, Цогт, Шарга сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ